

“ФИЛОСОФИ, ХҮНИЙ ЭРХИЙН УУЛЗВАРТ: “ЭКОЛОГИЙН ЁС ЗҮЙ” СЭДЭВТ ФИЛОСОФИЙН УЛСЫН XI ОЛИМПИАД

Үндэслэл:

Хүн төрөлхтний үйл ажиллагааны улмаас экосистем улам бүр доройтож буй энэ цаг үед залуусын байгаль болон хүрээлэн буй орчинд хандах хандлага, үнэлэмжийг өөрчлөх шаардлага бий. Тиймээс “экологийн ёс зүй”-н асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлж, байгалийн болон хүний оршихуйн асуудлыг философи, хүний эрхийн уулзварт эргэцүүлэх нь цаг үеийн чухал ач холбогдолтой сэдэв юм.

Зорилт:

Энэхүү олимпиад нь экологийн ёс зүйн үндсэн зарчмууд, үзэл санааг танин мэдэх, эргэцүүлэх, экологид хөнөөлгүй үйл ажиллагаа явуулах, ногоон амьдралын хэв маягыг түгээн дэлгэрүүлэх зорилтыг агуулж байна.

Хамрах хүрээ:

Монгол Улсын их, дээд сургуулийн философи, сэтгэлгээний түүх, соёл, эрх зүйн философийн хичээл судалж буй нэг ба хоёрдугаар курсын оюутнууд.

Сэдэв: Экологийн ёс зүй¹

- | | |
|-------------------|---|
| ▪ Амьтны эрх | ▪ Эгоцентризм |
| ▪ Газрын ёс зүй | ▪ Экогуманизм |
| ▪ Гүн экологи | ▪ Экологийн ёс зүйн зарчмууд |
| ▪ Экофеминизм | ▪ Байгаль хамгаалах уламжлал, зан үйл |
| ▪ Антропоцентризм | ▪ Экологийн ёс зүй: нийгмийн хариуцлага |
| ▪ Биоцентризм | ▪ Ногоон бодлого, ногоон хөгжил |

Үр дүн:

Энэхүү олимпиад нь философийн мэдлэгийг түгээх, сурталчилан таниулах, философийг сонирхон судлах оюутан залуусын хүрээг өргөжүүлэх, философийн хичээл зааж буй багш нарын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, харилцан бие биенээсээ суралцах талбар юм.

¹Дараах дэд агуулгаас сонгон илгэлийн даалгаварыг гүйцэтгэнэ.

Ашиглах материал:

1. Г.Лодой. Хүн ба байгалийн харилцааны тухай Л.Фейрбахын үзэл баримтлал. МУИС. PRS сэтгүүл. №9. (51). УБ.,2009. 25-30 дахь тал.
2. Р.Дарьхүү, Б.Насанбат. Экологийн ёс зүй дэх биотөвт үзэл баримтлал. МУИС. PRS сэтгүүл. №15.(391). УБ.,2013. 4-12 дахь тал.
3. Р.Дарьхүү. Олон соёлын хүрээнд экологи, шударга ёс, энх тайвны үйлсэд хамтран ажиллах философи. ЭШБХ-ийн эмхэтгэл. УБ.,2018. 52-69 дэх тал.
4. Б.Мөнхжавхлан, Б.Дагзмаа. Хүрээлэн буй орчны ёс зүйн асуудлууд. Хэрэглээний ёс зүйн асуудлууд. ЭШБХ-ын эмхэтгэл. УБ.,2017.56-65 дахь тал
5. Т.Дорждагва, Д.Батболд. Экологийн ёс зүйн боловсролын асуудалд. Монгол дахь ёс суртахууны боловсрол: “уламжлал, шинэчлэл. ЭШБХ-ын эмхэтгэл. УБ.,2016.41-50 дахь тал
6. Т.Дорждагва, Г.Мэнд-амар Экологийн ёс зүйд баримтлах зарчмуудын тухай. МУИС. PRS сэтгүүл. №17.(434). УБ.,2015.80-85 дахь тал.
7. С.Базарпүрэв, Б.Насанбат.Тогтвортой хөгжил: ёс суртахууны хариуцлагын асуудал. Мэргэжлийн ёс зүйн асуудал. ЭШБХ-ын эмхэтгэл. УБ.,2018. 103-112 дахь тал
8. Б.Наранбаатар. Экологийн ёс зүй ба хэрэглээний нийгэм. КТМС-ийн эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл. УБ.,2012. №2/125.
9. Г.Мэнд-амар. Хүн байгалийн харилцан хамаарлын тухай философи асуудал.Философи, эрхийн судлал. УБ.,2014. Боть ХХІХ.
10. М.Золзаяа нар. Бизнесийн ёс зүй гарын авлага. II Бүлэг. Экологийн ёс зүй. УБ.,2013
11. М.Золзаяа. Шинжлэх ухааны ёс зүй ба эрдэмтний мэргэжлийн хариуцлага. Илтгэл
12. Монголын Эмнести интернэшнл байгууллагаас гаргасан хүний эрхийн чиглэлийн холбогдох материалууд
- 13.


Олимпиадын хэлбэр: Илтгэл, тест, фото зураг, философийн эх зохиол дээр ажиллах, кино бүтээлээс философи утга санааг тайлбарлах, тохиолдол жишээ шинжлэх.

Шалгаруулалт: Багуудыг 2 үе шаттай шалгаруулна.

I шатны шалгаруулалт:

№	Гүйцэтгэх даалгавар	Тавигдахшаардлага	Шүүгчээс авах оноо
1	Илтгэл /3-5 мин/	• Үндсэн сэдэвтэй шууд холбоотой байх • Бүтээлч, шинэ санаа илэрхийлсэн байх • ЭША-д тавигдах ерөнхий шаардлага хангасан байх	15 оноо
2	Тес тажиллах /10 мин/	• Философи, философийн урсгал чиглэлүүд, хүний эрхийн агуулгаар тест ажиллах	20 оноо
3	Фото зургийн үзэсгэлэн гаргах /3 ширхэг/	• Үндсэн сэдэвтэй холбоотой фото зураг, эвлүүлэг, эсвэл шог зураг байх • Зургийн нэр, товч тайлбар, эсвэл уриаг баруун доод хэсэгт сургуулийнхаа логоны хамт 4*10 см хэмжээтэй хүрээнд байрлуулсан байх • Урьд нь олны хүртээл болоогүй байх • Цагаан хүрээтэй, хөөстэй стикер дээр хэвлэсэн байх • “Гамма фото студи”-д файлаа өгөөд хийлгэх бололцоотой. (99692048)	15 оноо
I шалгаруулалтын оноо:			50 оноо

Жишээ нь:



II шатны шалгаруулалт:

1. Философийн эх зохиолын утга санааг шүүн, тайлбарлах
2. Кино хэлэлцүүлэг хийх /I шатнаас шалгарсан 6 баг уг шатны эхний 2 тэмцээнд оролцоно/
3. Философи, ёс зүй асуудлаар тохиолдол шинжлэх. /Энэ хэсэгт сүүлийн 2 баг оролцон хоорондоо философи үндэслэгээ, дүгнэлт гарган мэтгэлцэнэ./

Дүгнэх журам:

1. Сэдвийн илэрхийлэл, философи үндэслэл, эргэцүүлэл хийсэн байдлыг харгалзан дүгнэнэ.
2. Оролцогчдыг шагнахдаа 1 багийн гишүүнийг давхардуулан шагнахгүй, өмнө жил шилдэг оюутнаар шалгарч байсан оюутныг дахин шагналд тодорхойлохгүй.

Байр, шагнал: Багийн шагнал

- I байр - 1: Өргөмжлөл, мөнгөн шагнал
II байр - 1: Өргөмжлөл, мөнгөн шагнал
III байр - 1: Өргөмжлөл, үнэ бүхий зүйл
IV байр - 1: Өргөмжлөл, үнэ бүхий зүйл

Оролцогчдын шагнал

- Уран илтгэгч - 1: Өргөмжлөл, үнэ бүхий зүйл
Мэргэн санаа дэвшүүлэгч- 1: Өргөмжлөл, үнэ бүхий зүйл

Бүртгэл:

ХААИС-ийн Төв байр, 315 тоот өрөөнд 2019 оны 11 дүгээр сарын 17-20-ны өдрийн 13:00-16:00 цагт бүртгэнэ. Бүртгүүлэхдээ дараах зүйлсийг бүрдүүлж ирсэн байна. Үүнд:

1. Олимпиадын сэдвийн агуулгыг илэрхийлсэн 3 фото зураг
2. Олимпиадад оролцох багийн нэр, гишүүдийн оюутны үнэмлэх. Жич: Нэг их, дээд сургуулиас 5 хүний бүрэлдэхүүнтэй зөвхөн нэг баг оролцоно. Багийн гишүүдийн хоёр нь тус олимпиадад өмнө нь 1 удаа оролцсон оюутан байж болно. Ингэхдээ тус оюутан нь хоёрдугаар курсын оюутан байна.
3. Бүртгэлийн мандат 20.000 төгрөг

Олимпиад:

2019 оны 11 дугаар сарын 22-ны Баасан гарагт 11:00 цагаас ХААИС-ийн Төв байрны Хатантуул театрт болно.

Үндсэн зохион байгуулагч:

ХААИС-ийн Эдийн засаг бизнесийн сургууль

Хамтран зохион байгуулагч:

Монголын Эмнести Интернэшнл
МУИС

Дэмжигч байгууллага:

ШУА, Философийн хүрээлэн
Монголын философийн холбоо

Холбоо барих:

ХААИС, Хичээлийн төв байрны 315 тоот. Багш, доктор М. Мөнхзул 96052578